



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/232

Мандалговь

Малын генетик нөөцийн төлөв байдлыг  
тодорхойлох, баталгаажуулалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, ХХААХҮЯ-амны сайдын 2019 оны 05 дүгээр сарын 07-ны өдрийн А/133 тоот тушаал, Аймгийн Засаг дарга, ХХААХҮЯ сайдтай 2019 онд хамтран ажиллах гэрээний 19 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд тоологдсон малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, баталгаажуулах, ашиг шимийн дундаж үзүүлэлтийг тогтоох ажлыг 2019 оны 06 сарын 17-ноос 2019 оны 10 сарын 01-ны дотор зохион байгуулсугай.

Хоёр. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, баталгаажуулах ажлыг хэсгийг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхжаргал), биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), ажлын хэсгийг орон нутагт ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж хамтран ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Ажлын тайлан, үр дүнг 2019 оны 10 сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438190621

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар  
сарын 05-ны өдрийн 133 дугаар  
захирамжийн хавсралт



#### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Нарийн бичгийн дарга: Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)  
Гишүүд: Б.Батгэрэл (Мэргэжлийн хяналтын газрын байцаагч)  
Ж.Шинэ-Уянга (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)  
И.Жамъянмядаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)  
С.Хорлоо (Хулд таван эрдэнэ ХХК, мал үржлийн нэгж)  
Д.Ариунгэрэл (Адаацаг ажнай ХХК, Мал үржлийн нэгж)  
Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 173 дугаар захирамжийн хавсралт

**МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ,  
ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Удирдамжийн зорилго:**

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэд Хүнс хөдөө аж ахуйн генетик нөөцийн олон улсын хороо байгуулагдаж Малын генетик нөөцийн интерлакены тунхгийг 2007 онд баталсан. Үүнийг дагаж урт хугацааны зорилготой 4 тэргүүлэх, 14 дэд тэргүүлэх чиглэл бүхий даян дэлхийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үүнийг гишүүн орон бүр дагаж мөрдөх ёстой бөгөөд улс орнуудын хүлээх үүргийг тодорхойлж өгсний нэг нь Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх асуудал юм.

**Хоёр. Хамрах хүрээ:**

Дундговь аймгийн 15 сумын малчид, мал бүхий иргэд

**Гурав. Хугацаа**

2019 оны 06 дугаар сарын 17-ноос эхлэн 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл

**Дөрөв. Ажиллах багийн бүрэлдэхүүн**

Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын засаг дарга түүний тамгын газар, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгж, төрийн бус байгууллагын ажилтнууд хуваарийн дагуу ажиллана.

**Тав. Гүйцэтгэх ажлууд**

1. Хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагаатай танилцах
2. Хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн биелэлтэд хяналт тавих, үр дүнтэй танилцах
3. Таван төрлийн малын амьдын жинг тогтоох нас тус бүрээр
4. Таван төрлийн малд хэмжилт хийх
5. Хониний ноосонд хяналтын хяргалт хийх
6. Таван төрлийн малд фенотип шинжилгээ хийх, анги чанар, үүлдэрлэг байдлыг тодорхойлох
7. Хашир туршлагатай малчидтай уулзаж санал солилцох
8. Орон нутгийн хээлтүүлэгч стандартын шаардлага хангаж байгаа үгүйд дүгнэлт өгөх
9. Орон мал сүргийг гадны аймаг, сумаас сайн чанарын хээлтүүлэгч авчирж малын чанар сайжруулж байгаа эсэхэд дүгнэлт өгөх.
10. Таван төрлийн малын одоо байгаа суурь түвшинд үндэслэж цаашид явуулах үржлийн ажлын чиглэлээ тодорхойлох
11. Аймгийн мал сүргийн тоо, түүнд суурилсан мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөв байдал /хүснэгт 1/, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн хандлага /хүснэгт 2/, үүлдэр омгийн малын эрсдэлийн түвшин /хүснэгт 3/, малын генетик нөөцийг удирдан зохион байгуулж буй бүтэц, зохион байгуулалт /хүснэгт 4/-ыг бүрэн гүйцэд үнэн зөв бүрдүүлэх

**Зургаа. Ажлын үр дүнг тайлагнах**

Ажлын хэсэг томилолтоор ажилласан үр дүнг илтгэх хуудас, судалгааны материалын хамт ХХААХҮЯ, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, сумдын Засаг дарга нарт хүргүүлнэ.